

БНСУ дахь COVID-19

Шинэчилсэн хувилбар

Хариу арга хэмжээ

Олон улсын хамтын ажиллагаа

Гадаад
харилцааны яам

БНСУ

6 дахь хувилбар

1. Солонгос дахь COVID-19-ийн байдал

- Өнөөг хүртэл үргэлжилж буй COVID-19 цар тахал нь урьд өмнө тохиолдож байгаагүй дэлхийн хямрал билээ. Энэ нь даян дэлхийн эрүүл мэндийн аюулгүй байдалд ноцтой аюул заналхийлэл болж, нийгмийн эрүүл мэндийн эрсдэлийг улам бүр нэмэгдүүлж байна.

Түүнчлэн хүмүүсийн зорчин явалт, бараа бүтээгдэхүүний эргэлтийг эрс бууруулж, глобал сүлжээг тасалдуулж, сандрал, айдас түгшүүр бий болгов. Үүний үр дүнд бидний хоорондын уялдаа холбоо хэр зэрэг эмзэг болохыг хүчтэй сануулж өглөө.

Цар тахлын улмаас амиа алдсан хүмүүсийн тоо өссөөр байна. Цар тахлын улмаас үүссэн нийгэм, эдийн засгийн хохирлын цар хүрээ одоогоор тодорхой бус байгаа ч эдгээр нь нийгмийн бүхий л түвшин өргөн хүрээтэй нөлөөлөх нь зайлшгүй.

- COVID-19 цар тахлын дэгдэлт Солонгос улсад эрт эхэлсэн юм. Хоёрдугаар сарын сүүлээр эхэлсэн Солонгост тохиолдсон анхны дэгдэлт тус улсын дотоодод айдас бий болгож, бусад олон улс Солонгосоос ирсэн аялагчдад хилээ хаасан юм.

Бидний зүгээс 3 дугаар сарын сүүлчээс 4 дүгээр сарын эх хүртэл олсон эерэг үр дүн, амжилт өөдрөг үзлийг аажмаар бий болгосон. Өдөр бүр тохиолддог шинэ тохиолдлын тоо хурдан буурч, өвчлөлт бага болсон бөгөөд нэг өдөрт хоёр тохиолдол бүртгэсэн хамгийн доод түвшин болсон юм.

Гэсэн хэдий ч 5 дугаар сарын эхээр нийслэл Сөүлийн бүсэд олон газраас кластерийн халдвар тархсан. Өдөрт шинээр гарч буй тохиолдлын тоо хоёр оронтой тоонд хүрч, бүлэг/олон нийтийн халдвар улсын хэмжээнд тархаж байна. Энэ нь хавтгайрсан муруй дахин дээшлэх (цар тахлын дэгдэлтийн бууралт эргэн өсөх) боломжтой гэдгийг хатуу сануулсан бөгөөд халдварын хоёр дахь давалгаа нь дэлхийн олон оронд бодитой гарсан юм.

- Цар тахлын нэрвэлтэд байсаар байгаа энэ цаг үед дэлхийн өнцөг булан бүрт янз бүрийн бодлого, хариу арга хэмжээний ярвигтай хослолыг үе шаттайгаар туршиж, үнэлгээ хийхэд цаг хугацаа бага байлаа. Солонгос нь цар тахлын гамшигт нэрвэгдсэн анхны улсуудын нэг тул COVID-19-ийн шинэ сорилтуудад хариу өгөхдөө бусдаас хэдэн алхмын түрүүнд явж байгаа юм.

Бид өөрсдийн туршлагаасаа бусадтай хуваалцаж, мэдлэгээ нэгтгэж байна. Ярилцлага, платформыг янз бүрийн түвшинд, мэргэжлийн хүрээнд зохион байгуулж ирлээ. Үүний заримаас дурдвал чөлөөтэй


нэвтрэх вэб семинарууд болон бусад нээлттэй эх сурвалж бүхий мэдээллүүдийг интернетээр түгээж, ашиглах боломжоор хангасан юм.

Түүнчлэн НҮБ, ДЭМБ, G20, АСЕАН, МИКТА зэрэг байгууллагуудтай тогтоосон, эсвэл ижил төстэй орнуудын хямралын үед албан бус байдлаар санаачилсан хоёр талт хийгээд олон талт харилцаа байв.

- Энэхүү баримт бичигт тусгагдсан бодлогууд нь Засгийн газрын хэлэлцүүлэг, шийдвэрийг боловсруулж, хурдан өөрчлөгдөж буй цар тахлын эсрэг бидний хариу үйлдлийг зохицуулах шийдвэрийн үр дүн юм. Энэхүү баримт бичиг нь өмнөх хувилбаруудын шинэчлэлт, өргөтгөл, нэмэлт хэлбэртэй болно.

1.1 Эхний давалгааны дараа

- Солонгост гарсан COVID-19-ийн анхны тохиолдол 1 дүгээр сарын сарын 20-нд батлагдсан. Эпидемийн дараагийн тархалт гурван үе шаттай явагдаж байна. Солонгост COVID-19-ийн нийт тохиолдол 8 дугаар сарын 5-ны байдлаар 14,423 байна.



- ♦ **(I үе шат: 1 дүгээр сарын 20-ны өдрөөс 2 дугаар сарын 17)** Эпидемийн эхний үе шатанд батлагдсан тохиолдол нь гадаадад аялагчид (17 өвчтөн), эсвэл тэдний ойр дотно хүмүүсээр (13 өвчтөн) хязгаарлагдаж байв. Өдөрт шинээр батлагдсан тохиолдлын тоо 1.03 болж, нийт 30 тохиолдол энэ үе шатанд бүртгэгдсэн байна.

Халдварт өвчний 4 шатлалт сэрэмжлүүлэг (цэнхэр-шар-улбар шар-улаан) 1 дүгээр сарын 27-ны өдөр 'шар'-аас 'улбар шар' болон өөрчлөгдсөн юм.

- ♦ **(II үе шат: 2 дугаар сарын 18-наас 5 дугаар сарын 5-ны хооронд)** Эпидемийн хоёр дахь үе шат нь тодорхой бүс нутаг, шашны нэг бүлэг орчимд төвлөрсөн шинж тэмдгээр илэрч байлаа. Түүнчлэн олон

хүмүүст халдвар тархах байдал эмнэлэг, дуудлагын төв зэрэг дээр илэрч байгаа нь ажиглагдсан. Энэ үе шатанд өдөрт дунджаар 138 шинэ тохиолдол гарч байсан бол 2 дугаар сарын 29-нд 909 шинэ тохиолдол бүртгэгдэж дээд цэгтээ хүрсэн юм.

Халдварт өвчний сэрэмжлүүлгийг 2 дугаар сарын 23-нд ‘улбар шар’-аас дээд түвшинд буюу ‘улаан’ болгож өсгөв. Халдварын тархалтыг зогсоох зорилгоор нийгмийн зай барих арга хэмжээг эхлээд 2 дугаар сарын 29-нд эхлүүлж, дараа нь 3 дугаар сарын 22-нд улам чангатгав.

Энэ үе шатанд нийт 10774 тохиолдол гарчээ. Эдгээр тохиолдлын 10.1% (1085 өвчтөн) хилийн чанадаас импортлогдсон болох нь тогтоогдов. 2 дугаар сарын 4-ний өдөр хилээр орж ирж буй зорчигчдыг нарийвчлан хянах зорилгоор нэвтрүүлэлтийн тусгай журмыг нэвтрүүлсэн. Дараа нь хилийн хяналт дахь нэмэлт арга хэмжээг гадаадад тархсан голомтын шилжих байршилд тохируулан үе шаттайгаар нэвтрүүлсэн юм.

- ◆ **(Ш үе шат: 5 дугаар сарын 6-наас хойш)** Эпидемийн энэ үе шатанд Сүүл хот дахь голомтоос (шөнийн клуб, том хэмжээний ложистикийн төвүүд, хүргэлтийн үйлчилгээний ажилтнууд, сүм хийдүүд) анх үүссэн жижиг бүлгүүдийн халдвараар дамжин бусад бүс нутагт тархсан юм.

II үе шатанд хэрэгжүүлж байсан нийгмийн зай барих арга хэмжээг 5 дугаар сарын 6-наас хойш зогсоож, урт хугацаанд илүү тогтвортой байхуйц хувийн болон олон нийтийн ёс зүйн дүрмийг боловсруулан танилцуулав.

Шинэ тохиолдлын тоо 8 дугаар сарын 5-ны байдлаар өдөрт дунджаар 40 орчим байв. Энэ үе шатны өөр нэгэн онцлог шинж бол гадаадаас зорчин ирэгчдийн дунд тохиолдож буй халдварын эзлэх хувь нэмэгдэж байгаа явдал. Хилийн чанадаас тээвэрлэгдэн улам бүр нэмэгдэж буй энэхүү эрсдлийн хариуд хилийн хяналт шалгалтын илүү хүчтэй арга хэмжээнүүдийг авч эхэлсэн юм.

1.2 Засаглалын үйл ажиллагаа

- COVID-19-д засаглалын хувьд өгсөн хариу арга хэмжээний ихэнх нь 2015 онд Ойрхи Дорнодын амьсгалын замын синдром (MERS)-ийн дэгдэлттэй тэмцэх явцад бий болсон туршлага, алдаа онооноосоо сургамж авсны үр дүн юм. MERS-ийн хямралын үр дагавар болж институцийн болоод эрх зүйн олон өөрчлөлт хийгдсэн билээ.

БНСУ-ын Өвчний хяналт, урьдчилан сэргийлэх төвийг халдварт өвчинтэй тэмцэх “хяналтын цамхаг” болгосноор энд илүү их эрх мэдэл, бие даасан байдлыг олгов. Төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн түншлэлийг дэмжих, оношилгооны иж бүрдэл, эмчилгээг яаралтай ашиглахыг

зөвшөөрөх, халдвар авсан хүмүүстэй холбоо барихад шаардлагатай мэдээллийг цуглуулах боломжийг эрүүл мэндийн байгууллагуудад олгох зорилгоор хуульд нэмэлт өөрчлөлт оруулав.

Хямралын үеийн мэдээлэл харилцааны ач холбогдлыг чухалчилж, олон нийтийн үнэн зөв, цаг алдалгүй мэдээлэл авах эрхийг хангах нь иргэдийн оролцоог нэмэгдүүлж, Засгийн газарт итгэх итгэлийг дээшлүүлэх маш чухал алхам болохыг мөн хүлээн зөвшөөрөв.

Олж авсан бас нэгэн сургамж бол төв, орон нутгийн засаг захиргааны хоорондын үр дүнтэй хамтын ажиллагааны ач холбогдол юм. Эдгээр бүхий л өөрчлөлтүүд нь COVID-19-д үзүүлэх манай хариу үйлдлийн суурь хүрээг хангаж өгсөн.

- Дэгү хот дахь дэгдэлт ихэссэн хоёрдугаар сарын 23-ны өдрөөс эхлэн COVID-19-ийн эрүүл мэндийн сэрэмжлүүлгийг хамгийн өндөр ("ноцтой") түвшинд хүртэл өндөрсгөснөөс хойш Солонгосын Засгийн газраас Засгийн газрын нэгдмэл арга барилыг баримталж ирэв. Ерөнхий сайд Засгийн газрын холбогдох бүх яамд, мөн арван долоон аймаг, томоохон хотуудаас бүрдсэн Гамшгаас хамгаалах, аюулгүй байдлын эсрэг арга хэмжээний төв штабын хурлыг даргалж ирлээ.
- ◆ Гамшгаас хамгаалах, аюулгүй байдлын эсрэг арга хэмжээний төв штабын хурал 2 дугаар сарын сүүлээс хойш 7 хоногийн 7 өдөр, тухайлбал 4 дүгээр сарын 15-нд болсон бүх нийтийн сонгуулийн өдөр ч хуралдаж байв. Онөөгийн байдлаар Ерөнхий сайд хорооны хуралдааныг долоо хоногт гурван удаа даргалж, үлдсэн хэсгийг Эрүүл мэнд, халамжийн сайд даргалдаг боллоо. Ерөнхий сайд шаардлагатай тохиолдолд түр хуралдаан зарлан хуралдуулдаг.
- ◆ Төв болон орон нутгийн засаг захиргааны дээд түвшний энэхүү өдөр тутмын уулзалт нь бэрхшээл, саатлыг тодорхойлж, шийдлийг олох, шийдвэрлэх арга хэмжээг шаардлагатай үед хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэв. Бид энэхүү арга барилаар улс орны хэмжээнд нөөцийг үр дүнтэй ашиглаж, хуваарилах боломжтой болсон. Жишээлбэл, дэгдэлтийн эхний үе шатанд Дэгү/Хойд Гёнсан мужид өвчлөл ихсэхэд олон өвчтөнийг эрчимт эмчилгээнд хамруулахаар бусад хот/муж руу шилжүүлсэн юм.
- ◆ Хоёр дахь том давалгаа 6 дугаар сард бодитоор нүүрлэх нь тодорхой болсон тул Гамшгаас хамгаалах, аюулгүй байдлын эсрэг арга хэмжээний төв штабаас 17 муж/хотын эрх баригчдын мэдэлд буй эмнэлгийн нөөцийг улс орон даяар 6 бүсийн кластерт хуваахаар шийдэв. Энэ нь өвчтөнүүдийг захиргааны шугамаар дамжуулах үед хүнд суртлын саадыг арилгах, эмнэлгийн ачаалал нэмэгдэхэд бэлтгэх зорилгоор эмнэлгийн ор, эмнэлгийн нөөцийг үр дүнтэй нэгтгэж, аюулгүйн нөөцийг бий болгох явдал байв.

Сөүл хот, зэргэлдээ орших Инчон хот болон түүний ойролцоох Кёнги мужийг хамруулсан Метрополитен кластерийн сургуулилтыг 6 дугаар сарын эхээр хийв. Долдугаар сарын эхээр Гванжу хотод өдөрт 50 орчим тохиолдол нэмэгдэхэд баруун өмнөд бүсийн кластер (Гуанжу хот болон зэргэлдээ Хойд ба Өмнөд Жолла мужуудыг хамруулсан) нөхцөл байдал хяналтад ортлоо сар орчим хугацаанд идэвхжсэн юм.

- ◆ Төв, орон нутгийн засаг захиргааны ажилтнуудын нягт хамтын ажиллагаа, хөдөлмөрийн хуваарилалт нь бие даасан хорио цээрийн арга хэмжээг үр дүнтэй удирдан зохион байгуулахад онцгой нөлөө үзүүлж, тохиолдол бүрийг томилогдсон албан тушаалтан хянаж, туслалцаа үзүүлж байв. Энэхүү харилцан уялдаатай, дасан зохицох арга нь COVID-19-ийн нийгэм, эдийн засгийн үр дагаврыг арилгах хамтын хүчин чармайлтын гол чиглэл хэвээр байх болно.
- Халдварт өвчний эсрэг авах шуурхай хариу арга хэмжээг сайжруулахын тулд өнөөгийн болон болзошгүй цар тахлын эсрэг Эрүүл мэнд, халамжийн яамны дэргэд үйл ажиллагаа явуулж буй Солонгос Улсын Өвчний хяналт, урьдчилан сэргийлэх төв (KCDC)-ийг Засгийн газрын бие даасан агентлаг болгон шинэчлэхээр шийдэв. Энэхүү шинээр байгуулагдсан “Өвчний хяналт, урьдчилан сэргийлэх агентлагт халдварт өвчинтэй холбоотой бодлого боловсруулж, хэрэгжүүлэх, төсөв, боловсон хүчин, зохион байгуулалтын асуудалд хяналт тавих бие даасан эрх мэдэл олгов.

Орон нутгийн засаг захиргаадын халдварт өвчинтэй холбоотой үйл ажиллагааг дэмжих зорилгоор “Өвчний хяналтын бүсийн төв”-ийг улсын хэмжээний томоохон мужуудад байгуулахаар шийдвэрлэв. Суурь ба хавсарга шинжлэх ухааны судалгаа, хөгжлийн хүчин чармайлтад зориулах хөрөнгө оруулалтыг өргөжүүлэхээр шийдвэрлэв.

2. Хилээ нээлттэй байлгах нь

- Дэлхийн Эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийг дагаж мөрдөхдөө бид хил дамнасан зорчих хөдөлгөөнтэй холбоотой эрсдлийг тооцсоны үндсэн дээр хилийн зорчих хөдөлгөөний тас хориглох бус, харин зорчин ирэгчдийн тээж явж болзошгүй вирусын халдварыг болон халдвар тархах зам мөрийг хянах, нарийвчлан зохицуулах замыг сонгосон болно. Эдгээр арга хэмжээг орж ирж буй эрсдлийн байршил, цар хүрээтэй тохируулан үе шаттай хийсэн болно.
- ◆ Эпидемийн эхний үе шатанд орж ирсэн аялагчдын эрүүл мэндийг болон зорчих хөдөлгөөнийг хянах зорилгоор нэвтрэх тусгай журам, хувь хүний эрүүл мэндийн өөрийн хяналтын аппликэйшнийг заавал ашиглуулах зэрэг хяналт тавих арга хэмжээнд анхаарлаа төвлөрүүлэв. Эхэндээ энэ нь зөвхөн өвчлөлд өндөр өртсөн цөөн тооны орны аялагчдад хамаатай байсан бөгөөд аажмаар өргөжүүлж ирсэн бүх аялагчдыг хамруулав.

- ◆ COVID-19-ийн импортын тохиолдол Солонгост шинээр гарч буй халдварын дийлэнх хувийг эзэлж байсан тул өвчлөл өндөр орнуудаас ирсэн зорчигчдод заавал хийх COVID-19-ын шинжилгээ, хорио цээрийн дэглэмийг нэвтрүүлэв. Улмаар уг арга хэмжээг ирсэн улс орноос нь үл хамааран хилээр орж ирж буй бүх зорчигчдыг хамруулан өргөжүүлсэн юм.

Мөн Солонгосоос явж буй аялагч жуулчдыг нэвтрэхийг хориглоогүй орнуудаас бусад тохиолдолд Солонгост визгүй нэвтрэх, визээс чөлөөлөх хөтөлбөрийг түр зогсоов. Мөн 6 дугаар сарын сүүлчээр тодорхой улс орнуудтай холбоотой онцлог хязгаарлалтыг нэвтрүүлж, виз олгох болон хуваарьт бус нислэгүүдийг түр хугацаагаар зогсоож, нэр бүхий хэд хэдэн орны аялагчдад Солонгос руу нисэх тийз олгохдоо PCR тестийн сөрөг хариу үзүүлэхийг шаардаж эхлэв. 8 дугаар сарын 5 гэхэд зургаан улс энэ схемд хамрагдав.

- Бизнес, анагаах ухаан, шинжлэх ухаан, хүмүүнлэгийн зорилгоор зорчигчид, мөн А1 (Дипломат), А2 (Албан) ба А3 (Гэрээ) визтэй, БНСУ-ын Элчин Сайдын Яам/Консулын газраас олгосон “тусгаарлалтын дэглэмээс чөлөөлөгдсөн” хүмүүст хилээ нээлттэй байлгаж байлаа.

Харин эдгээр аялагчдыг ирсэн хойно нь COVID-19-ийн шинжилгээнд хамруулж, сөрөг хариу гарсан тохиолдолд арван дөрвөн хоногийн турш идэвхтэй хяналт тавьж, эрүүл мэндийн байдлыг нь хянах аппликейшнээр дамжуулан эрүүл мэндийн нөхцөл байдлыг өдөр бүр тодорхойлж, Солонгост оршин сууж байх хугацаандаа эрүүл мэндийн байгууллагуудын утасны дуудлагад өдөр бүр хариулах зэрэг арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэв.

- БНСУ-ын Засгийн газраас аялал жуулчлал, ялангуяа бизнесийн зорилгоор хүндэтгэн үзэх шалтгаантай зорчих шаардлагатай солонгос иргэдийн гадаад улсуудад нэвтрэх үйл явцыг хөнгөвчлөх чиглэлээр гадаад орнуудтай хамтран ажиллаж ирлээ. Үүний үр дүнд өнөөдрийн байдлаар 15000 гаруй Солонгосын бизнес эрхлэгчид арван долоон оронд амжилттай зорчоод байна.

3. Нийгмээ нээлттэй байлгах нь

- БНСУ-ын Засгийн газар болон орон нутгийн засаг захиргаанаас иргэдийн зорчих эрх, эдийн засгийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох явдлыг аль болох бага байлгаж, өдөр тутмын амьдралынх нь нээлттэй байдлыг хадгалахын тулд иргэний нийгмийн байгууллагуудтай үйл ажиллагаагаа нягт уялдуулан ажилласан юм.

.

Бидний зүгээс хоёрдугаар сарын сүүлч, 3 дугаар сарын эхэнд тохиолдсон эхний давалгааны оргил үед ч хөл хорио зарлаагүй бөгөөд

нийтийн тээврийн хэрэгслийг түр зогсолт, бусад өргөн цар хүрээ бүхий хязгаарлалтгүйгээр үүнийг давж гарч чадсан болно. Мөн 4 дүгээр сард улс орон даяар парламентын сонгууль явуулсан төдийгүй онлайнаар явагдаж байсан бүх сургалтуудыг сургуулиуд дээр нь зохион байгуулах болсон юм.

3.1 Тест, Ажиглалт, Эмчилгээ (Test, Trace and Treat (3T))

- ◆ Энэ арга хэмжээний гол агуулга нь эерэг тохиолдлуудыг баталгаажуулах баталгаатай тест, цаашид тархахаас урьдчилан сэргийлэхийн тулд тэдгээрийн контактыг нарийн мөрдөх, халдвар авсан хүмүүсийг аль болох эрт эмчлэх гэсэн хэсгүүдээс бүрдсэн бидний **3Т стратеги** юм.

Өргөн цар хүрээг хамруулан явуулсан тест нь эерэг тохиолдлыг хурдан баталгаажуулж, тусгаарлах боломжийг олгосон. Мөрдөх багаж хэрэгслээр хангагдсан тархвар судлалын багууд хавьталд хамаарагчдыг түргэн шуурхай тогтоож, хорио цээр тогтоож байв. Өвчний шинж тэмдгүүдийн янз бүрийн түвшинд буй өвчтнүүдийг эрт эмчилгээнд хамруулах нь эмчилгээг үр дүнд хүргэх, нас баралтын түвшинг эрс бууруулж чадсан юм.

- ◆ Өвчтөнүүд болон тэдний ойрын хавьтлыг түргэн шуурхай тогтоож, тусгаарлах нь вирусын цаашдын тархалтаас урьдчилан сэргийлэх, нийгмийн бусад хэсгийн хөдөлгөөний эрх чөлөөг хадгалахад чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

Болзошгүй халдварын үед өвчтнүүдийн траектор-замын талаар нэрээ нууцалсан мэдээллийг олон нийтээс авах нь өвчин нийтэд тархах эрсдэлийн талаар сэрэмжлүүлэх, шинжилгээнд хамрагдахад нь чухал үүрэг гүйцэтгэлээ. Олон нийтэд цацагдсан энэхүү мэдээллийн нууцлалын асуудлыг шийдвэрлэхийн тулд Солонгос Улсын Өвчний хяналт, урьдчилан сэргийлэх төв (KCDC)-өөс нэрээ нууцалсан мэдээллийн хугацаа, хамрах хүрээг хязгаарлах удирдамжийг олон нийтэд нээлттэйгээр танилцуулав.

Солонгос Улсын Өвчний хяналт, урьдчилан сэргийлэх төв (KCDC) нь 3Т стратегийн хүрээнд хийгдсэн бүх алхамууд дахь хүний эрхийн үр дагаврын талаар бие даасан Хүний Эрхийн Үндэсний Комисстой тогтмол зөвлөлдөн ажиллаж байв.

- ◆ Метрополитен Сөүлийн бүсэд 5 дугаар сард гарсан шинэ тохиолдлуудын дараа бид холбоо барих-мөрдөх ажлыг хөнгөвчлөх зорилгоор зургадугаар сарын 10-наас эхлэн өндөр эрсдэлтэй газруудыг сонгон QR кодонд суурилсан бүртгэлийг нэвтрүүлэв.

Шөнийн клуб, кино театр зэрэг 90,000 орчим газрыг QR кодонд суурилсан заавал нэвтрэх бүртгэлийн системд 8 дугаар сарын байдлаар улс даяар хамруулав. Ухаалаг гар утасгүй, эсвэл QR код ашигладаггүй зочдод зориулж тухайн газрууд зочдыг бичгээр тэмдэглэл хөтлөх боломжоор

ханган ажиллав. Нууцлалыг баталгаажуулахын тулд QR кодоор сканнердах замаар цуглуулсан өгөгдлийг шифрлэж, холбоо барих мөрдөлтөд шаардлагатай нэрс, тухайн газарт зарцуулсан цаг хугацааны бүртгэл, холбоо барих мэдээллээр хязгаарладаг юм.

Тус тусад нь хуваарилсан QR код нь үйлчилгээ үзүүлэгчийн серверт хадгалагддаг бол тухайн газар, цагийн бүртгэлийн мэдээллийг Нийгмийн аюулгүй байдлын тагнуулын албаны серверт тусад нь нэгтгэдэг. Зөвхөн эрүүл мэндийн байгууллагуудын хүсэлтээр холбоо барих, мөрдөх зорилгоор мэдээллийн хоёр багцыг нэгтгэх боломжтой. Наймдугаар сарын 5-ны байдлаар 13 газраас 2211 мэдээллийн өгөгдөл цуглуулж, холбоо барих, мөр хайн тогтоох ажлыг гүйцэтгэжээ.

Бүх цуглуулсан өгөгдөл дөрвөн долоо хоногийн дараа серверүүдээс автоматаар бүрмөсөн устдаг юм.

3.2 Нийгмийн зай барих гурван түвшний аян

- ◆ Вирусын тархалтыг удаашруулахын тулд нийгмийн зай барих кампанит ажлыг 2 дугаар сарын 29-нд эхлүүлж, дараа нь COVID-19-ийн нөхцөл байдал өөрчлөгдөж байгаатай холбогдуулан өргөжүүлж, эсвэл бууруулж ажиллав. Анхны “нийгмийн зай барих аян” (2 дугаар сарын 29-нөөс 3 дугаар сарын 21-ний хооронд)-ны хүрээнд олон нийтэд хандан бүлэглэж олноороо цугларахаас зайлсхийхийг зөвлөж байв.

Дараа нь “Нийгмийн зай барих өргөжүүлсэн кампанит ажил” (3 дугаар сарын 22-ноос 4 дүгээр сарын 19-ний хооронд)-ыг сургуулиудыг орон даяар нээхээр төлөвлөсөнтэй холбогдуулан халдварын тархалтыг хүчтэй дарах зорилгоор хэрэгжүүлэв. Энэ үе шатанд олон нийтийг аль болох гэртээ байхыг зөвлөж, өндөр эрсдэлтэй газруудыг үйл ажиллагаагаа зогсоохыг зөвлөж байв.

Шинээр батлагдсан тохиолдлын тоо мэдэгдэхүйц буурсны дараа уг арга хэмжээг “Нийгмийн зай барилт” (4 дүгээр сарын 20-ноос 5 дугаар сар хүртэл) болгон хөнгөвчилж, дараа нь урт хугацаанд тогтвортой баримтлах хувийн болон олон нийтийн ёс зүйн кодын удирдамж болох “Өдөр тутмын амьдралд зай барих” (5 дугаар сарын 6-наас 6 дугаар сарын 28) кампанит ажил болгон үргэлжлүүлэв.

- ◆ Дээрх туршлагаас олж мэдсэн ойлголтууд дээрээ үндэслэн Засгийн газраас 6 дугаар сарын 28-ны өдөр нийгмийн зай барих гурван түвшний схемийг дэгдэлтийн нөхцөл байдлаас нь хамааруулан олон нийтэд ил тод мэдээлэх, харилцан тохирсон арга хэмжээ авах замаар системчлэв. Түвшин тус бүрийг хэзээ хэрэгжүүлж болох жишиг индексийг доор харуулав. Түвшинг улсын хэмжээнд эсвэл тухайн бүс нутагт тухайн нөхцөл байдалд тохируулан хэрэгжүүлнэ.

Хүснэгт 1: Нийгмийн гурван түвшний зайг тодорхойлох индекс

Хоёр долоо хоногийн турш	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3
Өдөр тутмын тохиолдлын тоо	50-аас доош	50-100	100-200 Долоо хоногт хоёр дахин нэмэгдэх
Тархвар тодорхойгүй	5%-аас бага	-	Огцом өсөлт
Нийтийн халдвар тархалт	Буурах, хяналтанд	Байнга өсөх	Огцом өсөх

- ◆ Түвшин 1 нь шинээр гарч буй тохиолдлын тоо нь эрүүл мэндийн одоогийн тогтолцооны удирдлага хяналтад байгааг харуулна. Урьдчилан сэргийлэх удирдамжийг баримтлан олон нийтийг өдөр тутмын амьдралаа үргэлжлүүлэн явуулахыг зөвлөж байна.

Түвшин 2 нь шинэ тохиолдлын тоо одоогийн эрүүл мэндийн системийн чадавхаас давж, олон нийтийн дунд тархах халдвар нэмэгдэж байгааг харуулна. Зайлшгүй бус нийгмийн харилцаанаас татгалзах, олон нийтийн цугларалтаас зайлсхийх, хүмүүстэй харьцах харьцаагаа багасгахыг зөвлөнө. Эрсдэл өндөртэй объектуудын үйл ажиллагааг зогсоож, олон нийтийн газрууд урьдчилан сэргийлэх арга хэмжээг дагаж мөрдүүлэх үүрэгтэй.

Түвшин 3-ыг тухайн бүс нутагт олон нийтийн халдвар дамжих, халдвар өндөр хурдтай тархаж, том хэмжээний дэгдэлт ажиглагдах үед хэрэгжүүлнэ. Олон нийтэд ажлаа хийх гэх мэт зайлшгүй шаардлагатай зүйлээс бусад нийгмийн харилцаа, гадуурх арга хэмжээ, зугаалгаас татгалзахыг зөвлөнө. Өндөр болон дунд эрсдэлтэй газруудыг хаах бөгөөд бусад бүх газруудад шөнийн цагаар ажиллахыг түр зогсоох зэрэг хязгаарлалтууд тавина.

Одоогийн байдлаар өдөр тутмын тохиолдлын тоог 50-аас доош байлгахуйц хэмжээнд буюу Түвшин 1-д байна.

3.3 Иргэний оролцоо

- ◆ Солонгос дахь COVID-19 цар тахлын дэгдэлтийг бууруулах нь иргэдийн оролцоо, идэвх чармайлт, олон нийттэй түншлэх харилцаанд хүчтэй тулгуурлаж байна.

Иргэд нийгмээрээ маск зүүх, хувийн хорио цээрийн арга хэмжээг дагаж мөрдөх, нийгмээс зай барих гэх мэт хувийн эрүүл ахуйн арга хэмжээг дагаж мөрдөж байна. Өөрийгөө хорио цээрийн дэглэмд хамруулсан хүмүүсийн дийлэнх нь шаардлагатай удирдамжийг бүрэн дагаж мөрддөг. 8 дугаар сарын 5-ны байдлаар 480,000 орчим тохиолдол бүртгэгдсэнээс зөвхөн 748 нь өөрийн хорио цээрийн дэглэмийг зөрчсөн байна.

Олон нийтийн оролцоо нь улс орон даяар иргэний хөдөлгөөний хэмжээнд хүрч, хүнд хэцүү бүс нутагт хариу арга хэмжээ авах ажилд сайн дурын ажил хийх, мөн анхаарлын гадна орхигдох магадлалтай эмзэг бүлгүүдийг дэмжих, тухайлбал бичиг баримтгүй гадаадын ажилчдад дэмжлэг үзүүлэх хэлбэрээр хэрэгжиж байна.

- ♦ MERS-ийн халдвар 2015 онд тархсантай холбоотой туулж өнгөрүүлсэн өнгөрсөн туршлагаасаа харахад Засгийн газарт итгэх олон нийтийн итгэл нь халдварт өвчний эсрэг иргэний оролцоо, идэвхжлийг бий болгоход чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд олон нийтийг бүрэн мэдээллээр хангаж баймааж тэдний итгэлийг олж авах боломжтой юм.

Цар тахлын эхний өдрөөс эхлэн хэвлэлийн бага хурлыг өдөрт хоёр удаа зохион байгуулж байна. Өглөө Эрүүл мэндийн сайд болон дэд сайд Гамшгаас хамгаалах, аюулгүй байдлын эсрэг төв штабыг төлөөлж, КСДС (Солонгосын Өвчнийг хянах төв)-ийн захирал болон Солонгосын Үндэсний Эрүүл Мэндийн Хүрээлэнгийн захирал үдээс хойш хуралд оролцож ирлээ.

Засгийн газрын үйл ажиллагааг бүрэн нээлттэй, ил тод байлгаж байгаа нь эргээд олон нийтийг илүү сайн шийдэл олох хүчин чармайлтад нэгдэхэд хүргэж ирлээ. Түүнчлэн үр дүнтэй хариу арга хэмжээ авахад саад болж болзошгүй ташаа мэдээлэл, хуурамч мэдээ, цуурхал тараахаас урьдчилан сэргийлж, "инфодемик" хэмээх өвчнийг хол байлгаж чадсан юм.

- ♦ Олон нийт ба Засгийн газрын түншлэл нь хариу арга хэмжээний шинэлэг арга хэмжээг боловсруулахад хүргэж чадлаа. Олон нийт мэдлэг чадвар, бүтээлч сэтгэлгээ, инновацийн асар их нөөцийг гаргаж, улмаар Засгийн газар олон нийтийн оролцоог дэмжин дайчилж институцчилсан юм.

Нэгэн сонирхолтой жишээ болох Солонгосын Эрүүл мэндийн нийгэмлэгээс анхлан нэвтрүүлсэн машинаа барин, эсвэл явган алхаан дундаа нэвтрэх үзлэгийн станцуудыг Засгийн газраас баталгаажуулж, стандартчилсан төдийгүй өргөнөөр нэвтрүүлснийг энд дурдаж болно.

Мөн Анагаах ухааны нийгэмлэгийн дэвшүүлсэн өөр нэг арга болох үндэсний мэдээллийн сангаар тоноглогдсон эмийн сангуудыг ашиглах явдлыг онцолж болох бөгөөд нийлүүлэлт нь олон нийтийн эрэлтэд хүрэхгүй байх үеийн маскны тоо хэмжээг тооцоолох схемийг гарган

давхардсан худалдан авалтаас урьдчилан сэргийлэх боломжийг бүрдүүлсэн явдал юм.

Засгийн газрын нээлттэй өгөгдлийг ашиглан хувийн хэвшил дэх программ хөгжүүлэгчид, стартапууд вирусын тархалтыг хянах, хэрэглэгчдийг болзошгүй эрсдэлээс сэрэмжлүүлэх, улсын хэмжээнд буй жижиглэн худалдаа эрхлэгчид, эмийн сан дахь маскны нөөцийг зааж өгөх зэрэгт хувь нэмэр оруулсан олон зуун апп, вэбсайт бий болгосон юм.

- ◆ Зургаан сарын дараа ч цар тахлын эцэс төгсгөл тодорхойгүй байж, олон нийтийн ядаргаа, бухимдлаас үүдэлтэй "корона блюз" ойлголт гарч ирсэн нь бодлого боловсруулагчдын хувьд улам бүр нэмэгдсэн сорилт болсон юм.

Нийгмийн зай барилтыг хадгалах нь хүмүүс хоорондын байнгын болон харилцан үйлчлэлийг алдагдуулдаг билээ. “Корона блюз” нь олон нийтийн зүгээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг дагаж мөрдөх сонирхолгүй болох эрсдэлтэй байдаг. Энэхүү бэрхшээлийг даван туулахын тулд бид урт хугацааны тогтвортой байдлыг анхаарч нийгмийн зай барих кампанит ажлаа тасралтгүй зохицуулж ирлээ. KCDC (Солонгосын Өвчнийг хянах төв) нь Солонгосын Сэтгэлзүйн холбоотой хамтран утсаар үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулж эхэллээ.

Эрүүл мэнд, халамжийн яам нь бүс нутгийн гэмтэл согог судлалын төвүүд, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран “COVID-19 Сэтгэлзүйн хамтарсан баг” байгуулж, хэрэгцээ шаардлагатай хүмүүст үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулав. Түүнчлэн өвчтөнүүд болон хувийн хорио цээрийн дэглэм сахиж буй хүмүүст зөвлөгөө өгдөг боллоо.

Засгийн газар 8 дугаар сарын 15-ны Бямба гарагт тохиосон Үндэсний эрх чөлөөний өдрийг наймдугаар сарын 17-ны амралтын өдрөөр сунган амралтын гурван өдөр болгож, эмнэлгийн ажилчид болон удаан үргэлжилсэн цар тахлын улмаас туйлдсан иргэддээ тусламж үзүүлэхээр болжээ.

3.4 Цоо шинэ сорилтууд

- ◆ Цар тахлын үеэс хойш Солонгост тулгарсан хамгийн том бэрхшээлийн нэг нь 4 дүгээр сарын 15-нд товлосон ёсоор бүх нийтийн сонгуулийг орон даяар явуулж, 5 дугаар сарын сүүлээс 6 дугаар сарын эхэнд сургуулиудын үйл ажиллагааг үе шаттайгаар нээсэн явдал байлаа.

Хоёр бэрхшээл хоёулаа улс орон даяар хүн хүч, нөөцийн шилжилт хөдөлгөөн цар тахлын тархалтыг түргэсгэж магадгүй гэсэн санаа зовнилыг дагуулж байв.

Мөн энэ хоёр тохиолдлын аль алинд аюулгүй ажиллагааны төрөл бүрийн арга хэмжээ авах, үйл ажиллагааны нарийвчилсан журам боловсруулах, аюулгүй ажиллагааны ажилтан, хамгаалалтын хэрэгслийг дайчлах шаардлагатай байв.

Сүүлийн 28 жилийн хугацаанд хамгийн өндөр сонгогчдын ирцтэй (66.2%) байсан бүх нийтийн сонгуулийг COVID-19-тэй холбоотой гэж өнөөг хүртэл үзэхгүй байна.

Сургуулиуд үйл ажиллагаагаа эхэлсний дараа 8 дугаар сарын эхээр нийт 78 оюутан, 13 багш ажиллагсад COVID-19-өөр өвчилсөн болно. Эдгээр хүмүүсийн ихэнх нь гэр бүлийн гишүүдтэйгээ ойр дотно харьцах, эсвэл сүм хийдийн үйл ажиллагаанд оролцох гэх мэт бүлгийн хавьтлаас халдвар авчээ. Одоогийн байдлаар ганцхан тохиолдлыг л сургуулийн үйл ажиллагаатай шууд холбон тайлбарлаж байна.

Оюутан/багш нарын дунд гарсан батлагдсан тохиолдлууд, мөн олон нийтийн халдвар ихсэх хандлагатай байгаа тул зарим сургуулиудыг тохиолдол бүрээр түр хугацаагаар онлайнгаар хичээллүүлэхээр болсон.

Орон даяар олон нийтийн халдвар ихэссэн 5 дугаар сарын сүүл үед 800 гаруй сургууль (нийт сургуулийн 4% орчим) танхимын хичээлээ цуцлах шаардлагатай болсон. Наймдугаар сарын 5-ны байдлаар хоёр аймгийн гурван сургууль COVID-19-ийн улмаас онлайн хичээлдээ эргэж орлоо. Сургуулийн орчинд халдварын тархалтыг зогсоох нь бэрхшээлтэй хэвээр байна.

- ◆ Өөр нэг тулгамдсан асуудал бол 8 дугаар сард тохиох сурагчдын амралт/зуны амралтын улирал, дотоодын аялал жуулчлал, хүмүүсийн зорчих хөдөлгөөний хүлээгдэж буй өсөлт юм.

Төв засгийн газар энэ хугацаанд халдвар тархах эрсдэлийг багасгахын тулд орон нутгийн удирдлагуудтай нягт хамтран ажиллаж байна. Жишээлбэл, амралтын үеэр авах арга хэмжээ болгож хүмүүсийн төдийлөн мэддэггүй ой хөвч, байгалийн нөөц газрууд гэх мэт эрсдэл багатай аялал жуулчлалын чиглэлийг сурталчлах, аялал жуулчлалын томоохон газрууд, байршлуудын аюулгүй байдлын арга хэмжээнд хяналт шалгалт хийх, нийгмийн зай барих дүрмийг дагаж мөрдөхийн ач холбогдлыг сурталчлах ажлыг хийж байна.

4. Олон улсын хамтын ажиллагаа

4.1 Мэдлэг туршлагаа хуваалцах ба бие биенээсээ суралцах нь: Глобал эв нэгдлийг уриалахуй

➤ COVID-19-ийн эсрэг үзүүлэх хариу арга хэмжээний талаарх хамтын ажиллагаанд системтэйгээр хариу өгөх үүднээс Гадаад харилцааны дэд сайдаар ахлуулсан яам хоорондын ажлын хэсэг байгуулав. Энэ Ажлын хэсэг нь ажлын хоёр урсгалд хяналт тавина: 1) Улс орны эмнэлгийн тоног төхөөрөмж, хэрэгсэл нь гадаад орнуудын эрэлт хэрэгцээг хангаж буй эсэх, 2) мэдлэг хуваалцах арга хэмжээ зохион байгуулах.

- ◆ Юуны өмнө, хүмүүнлэгийн тусламж эрэлхийлсэн хүсэлтэд хариу болгож, дотоодын тестийн иж бүрдэл, эмнэлгийн тоног төхөөрөмжийг худалдан авах хүсэлтэй гадаад орнуудын Засгийн газартай холбож өгөхийг эрмэлзэж байна.

Ерөнхийлөгч Мүн Жэ Ин энэ сарын 18-нд Дэлхийн эрүүл мэндийн ассемблей дээр 100 сая ам.долларын хүмүүнлэгийн тусламж үзүүлэхээ мэдэгдэв. Бид одоогийн байдлаар 97 оронд 41 сая гаруй ам.долларын хоёр талт тусламж үзүүлж, 32 улсад зориулан нэмж 12 сая ам.долларын тусламж үзүүлэхийн зэрэгцээ олон талт байгууллагуудад үзүүлэх дэмжлэгийн асуудлыг боловсруулж байна.

Маскны хувьд дотоодын хэрэгцээг хангахад хомсдол үүссэн тул экспортын хоригийг 3 дугаар сарын сүүлээс хэрэгжүүлж эхэлсэн. Гэхдээ 5 дугаар сарын эхээр энэ хомсдол арилснаар бид хүмүүнлэгийн зорилгоор энэ ажлыг эхлүүлэв. 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн мэс заслын маск үйлдвэрлэх дотоодын үйлдвэрлэлийн арван хувийг гадаадад экспортлох боломжтой болгов. Үүнийг одоо сар бүр дотоодын үйлдвэрлэлийн 50% болгон өргөжүүлээд байна.

- ◆ Хоёрдугаарт, гадаад түншүүдтэйгээ вэб семинар, видео хурал зохион байгуулж, COVID-19-тэй холбоотой асуудлуудыг харилцан хуваалцах мэдээллийн хуудсуудыг бэлтгэлээ.

Одоогийн байдлаар манай төрийн албан хаагчид болон янз бүрийн салбарын мэргэжилтнүүд COVID-19-ийн хариу арга хэмжээний талаарх үндэсний бодлого (5 дугаар сарын 4, 13, 27), Цагаачлал ба хилийн хяналт (6 дугаар сарын 2), Тархвар судлалын шинжилгээ зэрэг сэдвээр туршлагаа танилцуулав. Өдөр тутмын амьдралаас зай барих (6 дугаар сарын 17), К-Есопоту: Эдийн засгийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэх арга хэмжээ (6 дугаар сарын 24), Шинжлэх ухаан, Мэдээлэл харилцааны технологи ба боловсрол (7 дугаар сарын 1), Сонгуулийн арга хэмжээ (7 дугаар сарын 8). Энэ бүх видео бичлэг, танилцуулах материалыг Гадаад хэргийн яамны вэбсайт (www.mofa.go.kr/eng/brd/m_22741/list.do) дээрээс авах боломжтой.

➤ COVID-19 вирусын эсрэг вакцин болон эмчилгээний аргыг эрэлхийлэх нь дэлхийн өнцөг булан бүрт Засгийн газар, шинжлэх ухааны байгууллага, эм үйлдвэрлэгч компаниудын зүгээс урьд өмнө байгаагүй хүчин чармайлт, хамтын ажиллагааг идэвхжүүлсэн билээ.

Энэхүү дэлхий дахины үйл ажиллагааны нэг хэсгийг эрчимжүүлэхийн тулд Солонгосын Засгийн газар дотоодын судлаач, хөгжүүлэгчдийн хүчин чармайлтыг түргэтгэх, дэмжих зорилгоор Эрүүл мэндийн сайд, Шинжлэх ухаан, технологийн сайдын хамтарсан аж үйлдвэр, Засгийн газар, эрдэм шинжилгээний байгууллагын нөөц бололцоог дайчлах өндөр түвшний хороог 5 дугаар сард байгуулсан юм. Энэ ажилд 194 тэрбум вон (163 сая ам.доллар) хуваарилсан болно.

Мөн вакцин боловсруулж эхлэхэд түргэн, шударга, тэгш хүртээмжтэй байхын ач холбогдлыг ухамсарлан, вакцины хүртээмжтэй байдлыг хангах зорилготой COVID-19 вакцины дэлхийн хүртээмж (COVAX) зэрэг дэлхийн санаачлагыг дэмжиж байна. Шударга байдал, хүртээмжтэй байдлыг хангах нь зөвхөн тэгш байдлын асуудал биш бөгөөд цар тахлыг арилгах хамгийн хурдан арга юм.

- Бидний зүгээс COVID-19-ийн талаарх олон талт яриа хэлэлцээрт идэвхтэй оролцож байгаа бөгөөд тэдгээрийн зарим нь НҮБ, ДЭМБ, G20, АСЕАН, МИКТА зэрэг байгууллагуудын хүрээнд явагдаж байна. Бид бусад орнуудтай хамтран НҮБ дахь “Дэлхийн эрүүл мэндийн аюулгүй байдлын төлөөх эв санааны нэгдлийн анд нөхдийн бүлэг”-ийг байгууллаа. Энэхүү санаачилга нь сонирхсон гишүүн улс орнуудад дэлхийн эрүүл мэндийн тулгамдсан асуудалд хэрхэн үр дүнтэй хариу арга хэмжээ авах талаар санал бодлоо солилцох, практик, үйл ажиллагааны талаар албан бус платформ юм. Уг санаачлагыг хэрэгжүүлэн улс орнууд болон эрүүл мэндийн байгууллагуудын хамтын ажиллагааг хөнгөвчлөх, зохицуулах зорилгоор “Дэлхийн халдварт өвчний хариу арга хэмжээг дэмжих бүлэг”-ийг Женев хотноо ажиллуулж эхэллээ.

Түүнчлэн цар тахлын дунд маш хурдан тархаж буй үзэн ядалт, ялгаварлан гадуурхалт, гутаан доромжилсон асуудлуудыг шийдвэрлэхэд зориулагдсан ЮНЕСКО-ийн “Эв нэгдэл, дэлхийн иргэний боловсролын нөхөрлөлийн бүлэг”-ийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

4.2 COVID-19 хүчин чармайлтыг стандартчилах нь

- COVID-19-ийн хариу үйлдлээс олж мэдсэн зүйлээ олон улсын хамтын нийгэмлэгтэй хуваалцахын тулд бид олон улсын стандартчиллын байгууллага (ISO)-аар дамжуулан бодит цагийн RT PCR оношлогооны үйл ажиллагааны стандарт журмуудаас эхлээд үзлэгт машинаа барин болон яваан дундаа орох, нэвтрэх үзлэгийн цэгүүд, халдварт өвчнийг эмчлэх орон сууцны хорооллын эмчилгээний төвүүд болон эрүүл мэндийн өөрийн хөдөлгөөнт хяналт, хорио цээрийн хяналтын програмууд, туршлагаа стандартчилах үйл явцыг эхлүүлээ.

Эдгээр нь олон улсын стандарт (DIS)-ын урьдчилсан санал хураалтад хэдийнээ тэнцсэн бөгөөд ISO-д шинэ ажлын зүйл (NP) хэлбэрээр санал

болгосон болно. Цаашид бусад зүйлсийг боловсруулж санал болгохоор бэлтгэж байна.

- Мөн гадаад орнуудын холбогдох яамдтай хамтран халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах чиглэлээр хамтран ажиллах тухай хоёр талын загвар гэрээний төслийг боловсруулахаар ажиллаж байна. Энэхүү төслийг загвар болгон ашигласнаар олон улсын хамтын нийгэмлэгийн хүсэл эрмэлзэлий бүхий түншүүдтэй хамтран COVID-19 болон бусад халдварт өвчний талаарх хамтын ажиллагааг судалж, системчилнэ гэдэгт найдаж байна.

4.3 Дипломат шууд хамтын ажиллагааг үргэлжлүүлж байна

- Олон сарын турш үргэлжилсэн виртуал харилцааны дараа дэлхийн өнцөг булан бүрт нүүр тулсан дипломат харилцаагаа болгоомжтойгоор үргэлжлүүлж байна. Цар тахлын нөхцөлд энэ үйл ажиллагааг хариуцлагатай хийхийн тулд Гадаад харилцааны яамнаас яамны албан тушаалтнууд болон эрүүл мэндийн мэргэжилтнүүдээс бүрдсэн албан ёсны аяллын тэргүүлэх чиглэлийг батлах үүрэг бүхий Зөвлөл байгуулав. Энэхүү Зөвлөл нь дипломат аяллын зайлшгүй шаардлагатай байдлыг нэг бүрчлэн авч үзэж, өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар зөвлөгөө өгдөг.

Улс төрийн асуудал эрхэлсэн Гадаад хэргийн дэд сайд цар тахлын дараа Арабын Нэгдсэн Эмират улсад 6 дугаар сарын 13-наас 6 дугаар сарын 15-ны хооронд анхны гадаад айлчлал хийв. Солонгосын хойгийн энх тайван, аюулгүй байдлын асуудал эрхэлсэн Тусгай төлөөлөгч энэ сарын 17-ноос зургадугаар сарын 19-ний хооронд АНУ-д айлчиллаа..

- Өнгөрсөн хугацаанд БНСУ-д дипломат шугамаар зочлохоор ирсэн гадаадын зочид төлөөлөгчдийг угтан авах, айлчлалын туршид ирэхээс буцах хүртэлх хугацаанд хийгдэх ёстой тест, нийгмийн зай барилт зэргийг багтаасан вирусын халдварыг хамгийн бага байлгах дипломат протоколын дэлгэрэнгүй зааврыг бэлтгэлээ.

Айлчлан ирж буй талуудтай нягт хамтран ажилласны үр дүнд 7 дугаар сарын 6-нд Бүгд Найрамдах Узбекистан Улсын Хөрөнгө оруулалт, гадаад эдийн засгийн асуудал эрхэлсэн орлогч сайд, 7 дугаар сарын 7-ны өдөр Америкийн Нэгдсэн Улсын Төрийн нарийн бичгийн даргын орлогч, 7-р сарын 10-нд АНЭУ-ын Гадаад хэргийн сайдын айлчлалыг эх орондоо хүлээн авлаа.

5. Үл мэдэгдэх зүйл рүү: COVID-19-ийн дараах цаг үед бэлдэх нь

- Ковид-19 ба түүний улс орнууд, дэлхийн хамтын нийгэмлэгт үзүүлэх нөлөөний талаарх олон зүйлс хараахан ойлгомжгүй байсаар байна. Улс орнууд энэхүү хямралаас янз бүрийн арга замаар гарах учиртай. Шинэ асуудлууд гарч ирэхэд аль хэдийн үүссэн асуудлууд улам хурцдаж магадгүй

юм. Одоо ч гэсэн дэлхийн зарим хэсэгт шинэ тохиолдлын тоо буурч байхад заримд нь нэмэгдэж байна. Зарим нь гарах стратеги, баталгаатай арга хэмжээгээ аль хэдийнэ төлөвлөсөн бол зарим нь баримталж буй бодлогоо бэхжүүлж байна.

Нөхцөл байдал хяналтад байгаа мэт харж байгаа хүмүүсийн хувьд чиг хандлага эсрэг чиглэлд шилжих магадлалыг үгүйсгэх аргагүй юм. Магадгүй хил боомт, эдийн засаг нээгдэж магадгүй хэдий ч дараа дараагийн халдварын давалгаанд дахин удаашрах болно. Чухам юу тодорхой вэ гэвэл дэлхий нийтээрээ вирусээс найдвартай хамгаалагдахаас өмнө аль ч улс орон бүрэн аюулгүй байх боломжгүй юм. Дэлхийн хариу арга хэмжээ нь сорилтын цар хүрээтэй тохирч байх ёстой.

➤ Засгийн газар COVID-19-ийн дараах цаг үед бэлтгэхийн тулд Солонгосын эдийн засгийг технологи, дижиталчлалд бүтцийн хувьд зохицуулан өөрчлөх, нийгмийн аюулгүй байдлыг бэхжүүлж, нүүрстөрөгч багатай ногоон өсөлтийг дэмжих зорилго бүхий төслүүдийн багц бодлого болох “Солонгосын шинэ хэлэлцээр”-ийг саяхан зарлалаа. Энэ нь эрүүл мэндийн салбарын хямрал, цаг уурын өөрчлөлт болон бусад саад бэрхшээлтэй тулгарахад тэсвэртэй байхуйц хүртээмжтэй, тогтвортой эдийн засаг, нийгмийг бий болгоход оршиж байна. COVID-19-ийн дараах үеийн эдийн засгийн энэхүү үндсэн өөрчлөлтийг 2025 он хүртэл 160 их наяд вонын (133 тэрбум ам.доллар) хөрөнгө оруулалтаар дэмжих болно.

Үүний зэрэгцээ эдийн засгаа КОВИД-19-ийн цочролоос хурдан гаргах, бүх өрхөд аж ахуй эрхлэхэд нь туслах бэлэн мөнгөний бодлогыг санхүүжүүлэх, дотоодын хэрэглээг нэмэгдүүлэх, нийгмийн аюулгүй байдлын сүлжээг нөхөх зорилго бүхий манай түүхэн дэх хамгийн том хөшүүргийн багц 60 орчим их наяд вон (50 тэрбум ам.доллар)-ийн төсвийн тэлэх санаачилгыг цувралаар танилцууллаа.

➤ Дэлхийн эдийн засаг хэдийнээ уналтад ороод байгаа бөгөөд худалдаа, хөрөнгө оруулалтад тулгарч буй саад бэрхшээлүүд ирээдүйн сэргэлтийг удаашруулах төлөвтэй байна. Хүмүүс болон бараа бүтээгдэхүүний хил дамнасан шилжилт хөдөлгөөн сэргэх ёстой боловч илүү хэцүү, өндөр өртөгтэй, хязгаарлалттай байх магадлалтай байна.

Улс орнууд хил боомт, эдийн засгаа хэзээ, хэрхэн нээх вэ гэдэг нь Засгийн газруудын гаргах шийдвэрээс хамаарна. Цар тахлын учруулсан хохирлоос эдийн засгаа сэргээн босгохын зэрэгцээ дэлхий дахиныг хэрхэн чөлөөтэй, нээлттэй болгох вэ гэдэг нь томоохон сорилт байх болно..

➤ Өдгөө тулгарч буй хямрал нь шаардлагатай байгаа газарт үйл ажиллагаа, шинэтгэлийг идэвхжүүлэх, дэлхийн хамтын ажиллагааны цар хүрээг өргөжүүлэх боломж, эрч хүчийг бий болгоно гэдэгт найдаж байна. COVID-19-ийн урт хугацааны өв нь дэлхийн эв санааны нэгдэл, ирээдүйд илүү сайн

бэлэн байх, олон улсын хамтын нийгэмлэг энэ цаг үеийн хамгийн том сорилтыг даван туулахын төлөө байхад оршино.

---o0o---